



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/60

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Биеийн тамир спортын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Биеийн тамирын спортын Улсын хорооны даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/26 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/87 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн амыг хөдөлгөөний хомстлоос урьдчилан сэргийлэх, эрүүл амьдрах, зөв дадал хэвшилд сургах дасгал хөдөлгөөнөөр дархлааг дэмжих зорилготой Улсын хэмжээнд зохион байгуулагдаж буй “Илүүдэл жингүй-Эртэч Монгол” аян, “Илүүдэл жингүй-Эрүүл иргэнтэй Хөвсгөл” аяны хүрээнд “Мөрөн сумын аварга шалгаруулах нийтийн болон орчин цагийн бүжгийн тэмцээн”-ийг зохион байгуулах ажлыг аймгийн бүжгийн холбооны тэргүүн (Д.Цогтоо), эрүүл мэнд, нийтийн биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн (Д.Оюунсайхан) нарт даалгасугай.

2. Тэмцээний шагналд зарцуулах 1,000,000.00 (нэг сая) төгрөгийг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний зардлаас тооцож гаргахыг нягтлан бодогч (Т.Алтантуяа)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Нэргүй)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.БАТБАЯР

